



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 16 өдөр

Дугаар A/115

Мөрөн сум

**Хүнсний ногооны талбайг
нэмэгдүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн A/22 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолын дагуу орон нутгийн хамгаалалтаас чөлөөлөгдсөн газрыг төмс, хүнсний ногооны тариалалт эрхэлж буй талбай дээр нэмэгдүүлэн нийт 250 газар болгож төмс, хүнсний ногооны усалгаатай тариалан эрхлэх чиглэлээр нэмэгдүүлсүгэй.

2.Дээрх газрыг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан дээрх газрыг газрын нэгдсэн системд бүртгэж иргэдээс ирсэн газар эзэмших хүсэлттэй холбоотой харилцааг хуульд заасан үндэслэл журмын дагуу зохицуулахыг сумын газрын даамал (Г.Бат)-д даалгасугай

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Мягмаржав)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ХАТАНБААТАР